



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 07 дугаар сарын 29
№ 28 /937/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1656

Монгол Улсын
хууль

1657

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1718

Монгол Улсын Засгийн газрын
бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Засгийн газрын
бүтцийн тухай

Төрийн захиргааны байгууллагын
тогтолцоо, бүтцийн ерөнхий
бүдүүвчийг шинэчлэн батлах
тухай



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

538.	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	1656
539.	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай	1657
540.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1658
541.	Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1667
542.	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1668
543.	Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1668
544.	Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах тухай	1669
545.	Тахарын албаны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1669
546.	Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1669
547.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1670
548.	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1671
549.	Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1671
550.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1672
551.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай	1672
552.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1673
553.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1673
554.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1674
555.	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1675
556.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1675
557.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1676



558.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1678
559.	Орон сууц хувьчлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1679
560.	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1680
561.	Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1681
562.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1681
563.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай	1683
564.	Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1683
565.	Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1686
566.	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1687
567.	Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1689
568.	Хилийн боомтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1690
569.	Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1694
570.	Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1694
571.	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1702
572.	Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1711
573.	Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1711
574.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1712
575.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1713
576.	Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1713

577.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1714
578.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1714
579.	Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1715
580.	Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1715

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

581.	Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 08	1716
582.	Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай	Дугаар 09	1716
583.	Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 10	1717
584.	Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилох тухай	Дугаар 11	1717
585.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай	Дугаар 12	1718
586.	Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай	Дугаар 13	1721

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

587.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 91	1722
588.	Дипломат дээд цол хүртээх тухай	Дугаар 92	1722
589.	Монгол Улсын цол олгох тухай	Дугаар 93	1723
590.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 109	1723

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

591.	“Сайн оюутан” хөтөлбөр батлах тухай	Дугаар 229	1724
------	-------------------------------------	------------	------



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг доор дурдсанаар тогтоосугай:

1/Монгол Улсын Ерөнхий сайд;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайд;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайд;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;



15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний
сайд;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн
сайд.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс
эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцэд доор дурдсан
ям ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

- 1/Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 2/Батлан хамгаалахын яам;
- 3/Гадаад харилцааны яам;
- 4/Сангийн яам;
- 5/Хууль зүй, дотоод хэргийн яам;
- 6/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;

Чиглэлийн:

- 7/Барилга, хот байгуулалтын яам;
- 8/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам;
- 9/Зам, тээврийн хөгжлийн яам;
- 10/Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 11/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 12/Эрчим хүчний яам;
- 13/Эрүүл мэндийн яам.



2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай 18⁴ дүгээр зүйл нэмсүгэй:

“18⁴ дүгээр зүйл. Дэд сайдын бүрэн эрх

1. Дэд сайд сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд харьяа агентлаг, байгууллагатай харилцах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2/хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах;

3/сайдын даалгаснаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргатай харилцах;

4/Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий сайдаас байгуулах хороо, комисс, зөвлөл, ажлын хэсэгт сайдын түр эзгүйд түүний даалгаснаар сайдыг төлөөлөх;

5/хуульд заасан бусад бүрэн эрх.

2. Сайдын түр эзгүйд түүнийг орлож байх хугацаанд гаргасан шийдвэрээ сайдад танилцуулах бөгөөд уг шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна.

3. Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байна.

4. Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь түүнийг Засгийн газар томилсноор эхэлж, тухайн дэд сайдыг шинээр томилсноор дуусгавар болно.



5.Дэд сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

6.Дэд сайдыг орон гарсан тохиолдолд Засгийн газар 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно. Нөхөн томилогдсон дэд сайдын бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

7.Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр огцорсон, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг уг албан тушаалд дахин томилоход саад болохгүй.

8.Сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ дэд сайд Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно.

10.Дэд сайд бодлогын асуудлаар сайдтай санал зөрснөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно. Харин энэ талаар эцсийн шийдвэр гартал үүрэгт ажлаа гүйцэтгэж, хариуцлагыг нь хүлээнэ.

2 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “тэргүүлнэ.” гэсний дараа “Сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, агентлагийн үйл ажиллагааг сайдын өмнө хариуцах үүрэг бүхий дэд сайд байна.” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

- 1/Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 2/Батлан хамгаалахын яам;
- 3/Гадаад харилцааны яам;
- 4/Сангийн яам;
- 5/Хууль зүй, дотоод хэргийн яам;
- 6/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;



Чиглэлийн:

- 7/Барилга, хот байгуулалтын яам;
- 8/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам;
- 9/Зам, тээврийн хөгжлийн яам;
- 10/Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 11/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 12/Эрчим хүчний яам;
- 13/Эрүүл мэндийн яам.

2/20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь асуудал хамаарна:

-улсын хөгжлийн цогц бодлого;
-эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;

-хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;
-гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;

-концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого;
-төрийн өмчийн бодлого;
-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа;

-цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах бодлого;

-тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал;

-харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал.”

3/20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

1/Монгол Улсын Шадар сайд:

-гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал;
-хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал;



асуудал; -стандартчилал, хэмжил зүйн асуудал;
-шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах

асуудал. -хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;
-тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
-чөлөөт бүсийн хөгжлийн асуудал;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

газрын дарга: 2/Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх

удирдлага; -Засгийн газрын шийдвэрийн биелэлт;
-Засгийн газрын дотоод мэдээлэл;
-Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;
-төрийн албаны хүний нөөцийн асуудал;
-орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого;
-орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт,

хангах асуудал; -Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар

зүйн туслалцаа; -иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга

асуудал. -агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

3/Байгаль орчин, аялал жуулчлалын сайд:

сэргээх болон экологийн бодлого; -ногоон хөгжлийн бодлого;
-байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн

асуудал; -газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого;
-цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
-усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах

мэдээллийн сан; -ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал,

болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;

-биоаюулгүй байдлын бодлогын асуудал;



-аялал жуулчлалын бодлого;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

асуудал. -агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

4/Батлан хамгаалахын сайд:

бодлого; -улсыг батлан хамгаалах бодлого болон цэргийн

асуудал; -зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;
-энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах

асуудал. -агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

5/Гадаад харилцааны сайд:

талаархи хамтын ажиллагаа; -гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн

ашгийг хамгаалах асуудал; -гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа;
-гадаад худалдааны бодлого;
-гадаадад байгаа Монгол Улсын иргэн, бизнесийн эрх

хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;

чиглэлээрх хамтын ажиллагаа; -гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн

асуудал. -дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;
-гадаад сурталчилгаа;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

6/Сангийн сайд:

асуудал; -макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт;
-улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн

удирдлагын асуудал; -санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн



-нэгдсэн төсвийн талаархи судалгаа, төлөвлөлт;
-төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа;

хяналт; -улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын

-зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
-нягтлан бодох бүртгэлийн бодлого;
-гаалийн бодлого;
-татварын бодлого;
-даатгалын бодлого;
-хилийн боомтын хөгжлийн асуудал;
-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бодлого;

асуудал. -агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

7/Хууль зүй, дотоод хэргийн сайд:

-эрх зүйн шинэтгэлийн бодлого;
-хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;

-эрх зүйн туслалцаа;
-улсын хил хамгааллын асуудал;
-цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;

-шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
-Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;

-төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
-иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
-энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;

-төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;

бүртгэл; -иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын

-хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
-оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
-архивын талаар төрөөс баримтлах бодлого;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.



8/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд:

-хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;
-нийгмийн халамжийн бодлого;
-нийгмийн даатгалын бодлого;
-хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын болон гэр бүлийн хөгжлийн асуудал;

-жендэрийн хөгжлийн асуудал;
-хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал;
-хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;

-хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын ертгийн талаархи асуудал;

-хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;

-хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт;
-хөдөлмөрийн биржийн асуудал;
-Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;

-гадаадад ажиллах хүч гаргах асуудал;
-мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тогтолцоог хөгжүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

9/Барилга, хот байгуулалтын сайд:

-барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;

-хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;

-орон сууцны бодлого;
-нийтийн аж ахуйн асуудал;
-газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

10/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд:



асуудал; -боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;
-шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын

бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал; -өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог

нэмэгдүүлэх асуудал; -ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого;
-соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;
-түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;
-нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;
-мэргэжлийн спортын хөгжлийн асуудал;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг

асуудал. -агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

11/Зам, тээврийн хөгжлийн сайд:

нэмэгдүүлэх асуудал; -авто замын асуудал;
-авто тээврийн асуудал;
-төмөр замын тээврийн асуудал;
-иргэний нисэхийн асуудал;
-далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;
-тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг

асуудал. -агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

12/Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд:

нөөцийн талаарх бодлого; -геологи, эрдэс баялгийн бодлого;
-геологийн эрэл, хайгуул, судалгааны зохицуулалт;
-газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний

ашиглах асуудал; -цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги

экспорт, импортын асуудал; -олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;
-ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого;
-хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал;
-эрдэс баялаг болон хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний

асуудал. -аж үйлдвэрийн паркийн асуудал;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх



13/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд:

бодлого;
-хүн амын хүнсний хангамжийн бодлого;
-хүнсний аюулгүй байдлын асуудал;
-мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
-газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
-мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах

асуудал;
-мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;
-бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах

эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;

-хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;

бодлого;
-малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах

асуудал.
-хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын асуудал;
-жигжиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;
-дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх

14/Эрчим хүчний сайд:

асуудал;
-эрчим хүчний нэгдсэн бодлого;
-эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн

бодлого;
-сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;
-эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах

нэмэгдүүлэх асуудал;
-түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;
-эрчим хүч хэмнэлтийн бодлого;
-эрчим хүчний нүүрсний асуудал;
-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг

асуудал.
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх



15/Эрүүл мэндийн сайд:

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;

-эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаархи бодлого;

-эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;

-хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ;

-салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;

-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.”

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.8.дэд сайд, Ерөнхий сайдын зөвлөх;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “сайд” гэсний дараа ”, дэд сайд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ТАХАРЫН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Тахарын албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2.5 дахь заалтын “, тахарын” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн



9.1.7 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “түүнчлэн” гэсний дараа “сэжигтэн, яллагдагчийг” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь заалтын “тахарын алба” гэснийг “цагдаагийн, хэрэв уг этгээд баривчлах, хорих ял эдэлж байгаа бол ял эдлүүлж байсан баривчлах байр, хорих анги нь тус тус” гэж, 113 дугаар зүйлийн 113.1 дэх хэсгийн “оргосон” гэснийг “баривчлах байр, хорих ангиас оргосон яллагдагч,” гэж, мөн зүйлийн 113.2 дахь хэсгийн “Оргосон” гэснийг “Баривчлах байр, хорих ангиас оргосон яллагдагч,” гэж, 130 дугаар зүйлийн 130.5 дахь хэсгийн “Тахарын” гэснийг “цагдаагийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийн “тахарын албатай хамтран” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 9.2.6, 9.2.7 дахь заалт нэмсүгэй:

“9.2.6.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах, баривчлах;

9.2.7.яллагдагчийг шүүхэд хуяглан хүргэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “тахарын алба” гэснийг “цагдаагийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтын “тахарын” гэснийг “цагдаагийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.10 дахь хэсгийн “тахарын” гэснийг “цагдаагийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын “Тахарын албаны алба хаагч” гэснийг “мөрдөн байцаагч” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “Тахарын алба нь” гэснийг “Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь” гэж, мөн зүйлийн 23.3 дахь хэсгийн “Тахарын алба” гэснийг “Энэ хуулийн 23.2-т заасан хамгаалалтын тусгай нэгж” гэж, мөн зүйлийн 23.4 дэх хэсгийн “Тахарын албаны хамгаалалтын” гэснийг “Энэ хуулийн 23.2-т заасан” гэж, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн “Тахарын алба” гэснийг “энэ хуулийн 23.2-т заасан байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “, Тахарын албаны алба хаагч” гэснийг тус тус хассугай.



3 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 12¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“12¹ дүгээр зүйл. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

12¹.1. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12¹.1.1. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн талаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12¹.1.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах.

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, 28 дугаар зүйлийн 28.3, 28.4, 28.5, 28.6, 28.9 дэх хэсгийн “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.



3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.Хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчид үйлчилгээ үзүүлэх зэрэг чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтын “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, 13 дугаар зүйлийн 13.2, 13.5 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийн “Санхүү,



төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/9¹ дүгээр зүйл:

“9¹ дүгээр зүйл.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ. Дарга, орон тооны бус гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө.

3.Аймаг, нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллана.

4.Төрийн өмчийн төлөөлөгчийн эрх, үүрэг, ажиллах журмыг Засгийн газар батална.”

2/21¹ дүгээр зүйлийн 2¹ дэх хэсэг:



“2¹.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналыг хянаж, нэгтгэн санал дүгнэлтийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.”

3/2¹ дүгээр зүйлийн 3¹ дэх хэсэг:

“3¹.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “гаргаж,” гэсний дараа “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,” гэж, 66 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Сангийн яам нь” гэсний дараа “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт, 21¹ дүгээр зүйлийн 1, 10 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2, 4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 1, 3, 5 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 45 дугаар зүйл, 46 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт, 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 55 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 57 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 65² дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 65³ дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 65⁴ дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 65⁵ дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 70 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 82



дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, 11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 5, 15 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 45 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, 21¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэж, 65 дугаар зүйлийн 1, 2 дэх хэсгийн “санхүү, төсвийн” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын” гэж, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “яамнаас” гэснийг “яам болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “дүнгийн мөрөөр” гэснийг “дүнг хамтран” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“53.1. Энэ хуулиар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.”



2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсгийн “худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 53.5, 53.7 дахь хэсгийн “Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага” гэснийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.3, 53.4, 53.6 дахь хэсгийн болон 53.5.2, 53.5.6 дахь заалтын “худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж, 53 дугаар зүйлийн 53.6 дахь хэсгийн “Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын” гэснийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Сангийн яам” гэснийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “Сангийн яамтай” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэж, 9 дүгээр зүйлийн гарчиг, 23 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Сангийн яамны” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж, 9



дүгээр зүйлийн гарчгийн “Сангийн яамны” гэснийг “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж, 23 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Сангийн яаманд” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2 заалтын “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалтын “байгууллагын” гэснийг “болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.1.Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын нийгмийн даатгалын байцаагчаас бүрдэнэ.”

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.8 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, 7.2.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, мөн зүйлийн 21.5.1, 21.5.2 дахь заалтын “эрүүл мэндийн даатгалын байгууллага” гэснийг “нийгмийн даатгалын байгууллага” гэж, 10 дугаар



зүйлийн 10.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1, 22.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын байгууллага” гэснийг “Нийгмийн даатгалын байгууллага” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтын “эрүүл мэндийн даатгалын байгууллагатай” гэснийг “нийгмийн даатгалын байгууллагатай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай” гэснийг “Нийгмийн даатгалын байгууллагатай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийн “эрүүл мэндийн даатгалын байгууллагаас” гэснийг “нийгмийн даатгалын байгууллагаас” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл” гэснийг “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “эрүүл мэндийн даатгалын байгууллагад” гэснийг “нийгмийн даатгалын байгууллагад” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.8.1, 14.9.1, 14.9.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.1.6 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийн “эрүүл мэндийн даатгалын байгууллагын” гэснийг “нийгмийн даатгалын байгууллагын” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын” гэснийг “Нийгмийн даатгалын байгууллагын” гэж, 7 дугаар зүйлийн гарчиг, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.1, 18.3, 18.4 дэх хэсгийн “Эрүүл мэндийн даатгалын улсын” гэснийг “Нийгмийн даатгалын улсын” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын “эрүүл мэндийн даатгалын байгууллагаар” гэснийг “нийгмийн даатгалын байгууллагаар” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.3, 14.9.4, 14.9.5, 14.9.6 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “энэ хуулийн 14.9.6-д заасан журмын дагуу” гэснийг, мөн зүйлийн 16.1.6 дахь заалтын “14.9.3-14.9.6-д” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “болон эрүүл мэндийн” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалтын “энэ хуулийн 14.7-д” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7 дахь хэсэг, 15 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.



5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Статистикийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/13¹ дүгээр зүйл:

“13¹ дүгээр зүйл.Үндэсний статистикийн хорооны удирдлага



“13¹.1.Үндэсний статистикийн хороо Дэд даргатай байна. Дэд даргыг Үндэсний статистикийн хорооны дарга томилно.

13¹.2.Үндэсний статистикийн хорооны дарга, дэд даргыг томилохдоо түүний эдийн засаг, статистик, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана.

13¹.3.Үндэсний статистикийн хорооны даргын цалинг Улсын Их Хурал тогтооно.

13¹.4.Үндэсний статистикийн хорооны даргын бүрэн эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

1/хуульд заасан бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;
2/эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй болсон;

3/албан тушаалаас чөлөөлж өгөхийг өөрөө хүссэн;
4/үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;
5/гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шийдвэр нь хүчин төгөлдөр болсон.”

2/15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7/Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцох;”

3/15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Үндэсний статистикийн хорооны дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

1/төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон цалин авч, шаардлагатай бусад хангамж эдлэх;

2/уналга, холбооны хэрэгслээр хангагдах;
3/хуулиар тогтоосон бусад баталгаа.”

2 дугаар зүйл.Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“1.Үндэсний статистикийн хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаагаар томилно.

2.Үндэсний статистикийн хорооны дарга үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд хариуцан тайлагнана.”

3 дугаар зүйл.Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн “Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний статистикийн хороо” гэж, 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Үндэсний статистикийн хороо” гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Үндэсний статистикийн хороонд” гэж, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 6 дахь заалтын “статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэснийг “Үндэсний статистикийн хороонд” гэж, 13, 14, 15, 15¹ дүгээр зүйлийн гарчиг, 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэснийг “Үндэсний статистикийн хорооны” гэж, 7 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэснийг “Үндэсний статистикийн хорооны” гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын “статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг” гэснийг “Үндэсний статистикийн хороог” гэж, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 8 дахь заалт, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “Үндэсний статистикийн хорооноос” гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дугаарыг “8” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуульд доор дурдсан агуулгатай 13¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“13¹ дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/төрөөс соёлын талаар баримтлах бодлого, соёлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

2/дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглох арга хэмжээ авах;

3/соёлын тоо бүртгэл хөтөлж, дүн шинжилгээ хийх;
4/түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

5/түүх, соёлын дурсгалт зүйлийг судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, ашиглалт, хамгаалалтад хяналт тавих ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, гадаад, дотоодод үзэсгэлэн гаргах ажлыг зохион байгуулах;

6/утга соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалах, өвлүүлэх, судалж сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, утга соёлын өвийг өвлөн тээгч билиг авьяастныг судлан тодорхойлж, эрдэм авьяасыг нь хойч үед уламжлуулахад туслан дэмжлэг үзүүлэх;

7/ардын язгуур урлагийн чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

8/дүрслэх урлаг, дизайны чиглэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;



9/соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

10/хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн “төрийн захиргааны төв байгууллага,” гэсний дараа “төрийн захиргааны байгууллага,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1/төрөөс соёлын талаар баримтлах бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, соёлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах;”

4 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 8, 9, 15, 16, 17, 18, 19 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай 14¹ дүгээр зүйл нэмсүгэй:

**“14¹ дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн
захиргааны байгууллагын бүрэн эрх**

14¹.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын өвийг хамгаалах чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



14¹.1.1.төрөөс соёлын өвийг хамгаалах талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

14¹.1.2.соёлын өвийн улсын үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, дүнг Засгийн газарт тайлагнах;

14¹.1.3.соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах;

14¹.1.4.соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх;

14¹.1.5.соёлын өвийг хувилах, бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;

14¹.1.6.дуудлага худалдаагаар худалдах соёлын биет өвийн бүртгэлийг хөтлөх, тайланг хүлээн авах, хяналт тавих;

14¹.1.7.нийтийн өмчийн соёлын өвийг хадгалах, бүртгэх ажлыг мэргэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

14¹.1.8.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14¹.1.9.соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг хөтлөх;

14¹.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “, төрийн захиргааны байгууллага” гэж, мөн зүйлийн 37.2 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага,” гэсний дараа “төрийн захиргааны байгууллага,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн



52.7, 52.8 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэг, 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 14.1.3, 14.1.7, 14.1.8, 14.1.9, 14.1.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын тухай хуульд доор дурдсан агуулгатай 8¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“8¹ дүгээр зүйл.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

8¹.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8¹.1.1.төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

8¹.1.2.бүх насны ангиллын биеийн тамир-чийрэгжүүлэлтийн нормативыг боловсруулан батлах;

8¹.1.3.улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох;

8¹.1.4.биеийн тамир, спортын улсын мэдээллийн санг бүрдүүлэх;

8¹.1.5.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах;



8¹.1.6.биеийн тамирыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёс болгон хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

8¹.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

8¹.2.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, дүүрэгт биеийн тамир, спортын хороо, суманд биеийн тамир, спортын орон тооны бус арга зүйчтэй байна.”

2 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэсний дараа “, төрийн захиргааны” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 8¹ дүгээр зүйлийн дугаарыг “8²” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “төв” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6, 8.1.7, 8.1.8, 8.1.9 дэх заалт, 8.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ХИЛИЙН БООМТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хилийн боомтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг:

“15.5.Боомтын аюулгүй байдлыг хангах журмыг хил хамгаалах байгууллагын дарга батална.”

2/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:

“16.6.Хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь боомтын хяналтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.”

2 дугаар зүйл.Хилийн боомтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “эрх бүхий” гэсний дараа “хил хамгаалах,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хилийн боомтын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:

“16.1.Хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь боомтын хяналтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг уялдуулан, ерөнхий зохицуулалтаар хангаж ажиллана.”

2/16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг:

“16.5.Хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь боомтын асуудлаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.5.1.боомтод мөрдөх нийтлэг журмыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг ерөнхий зохицуулалтаар хангах;

16.5.2.боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Боомтын үндэсний зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

16.5.3.боомтод хийх хөрөнгө оруулалтад захиалагчаар оролцох;

16.5.4.боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, холбогдох төслийн дагуу боомтын дэд бүтцийг барих, өргөтгөх үйл ажиллагаанд хяналт тавих;

16.5.5.боомтын хяналт шалгалт болон иргэдэд үзүүлэх үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад нийцүүлэн шуурхай,



чирэгдэлгүй зохион байгуулах, боловсронгуй болгоход шаардагдах эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

16.5.6.үйл ажиллагааны зорилго, чиг үүрэгт хамаарах асуудлаар Боомтын үндэсний зөвлөлд санал оруулж, шийдвэрлүүлэх;

16.5.7.боомтод үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдээс гүйцэтгэсэн ажил, үйлчилгээтэй холбоотой статистик дүн, мэдээ, судалгааг үнэ төлбөргүй гаргуулан авах;

16.5.8.хууль тогтоомж, Боомтын үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэл, удирдамжийн хүрээнд өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллах;

16.5.9.төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын түншлэлийг дэмжих замаар боомтын үйл ажиллагаанд үйлчилгээний дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх;

16.5.10.боомтын хяналтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, үйл ажиллагаанд нь шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

16.5.11.төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх, худалдааг хөнгөвчлөх, цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

16.5.12.боомтын бүсэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

16.5.13.боомтын дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулах, засвар, үйлчилгээ хийх ажлыг хариуцан зохион байгуулах;

16.5.14.энэ хуулийн 17.4.6-д заасан журамд нийцүүлэн тухайн боомтод мөрдөх журмыг батлах;

16.5.15.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.”

4 дүгээр зүйл.Хилийн боомтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтын “иргэний

харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн,” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “Гадаадын иргэн, харьяатын” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “энэ хуулийн 18.3-т заасан Боомтын захиргааны дарга” гэснийг “хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “энэ хуулийн 16.1-д заасан Боомтын нэгдсэн захиргаа” гэснийг “Боомтын үндэсний зөвлөл” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “энэ хуулийн 18.1-д заасан Боомтын захиргаа” гэснийг “Боомтын үндэсний зөвлөлийн дарга” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Боомтын нэгдсэн захиргааны дарга гэснийг ”Боомтын үндэсний зөвлөл” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Боомтын захиргаанаас” гэснийг “хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэж, мөн зүйлийн 12.3 дахь хэсгийн “Боомтын нэгдсэн захиргааны дарга” гэснийг “Боомтын үндэсний зөвлөл” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг болон мөн зүйлийн гарчгийн “Боомтын нэгдсэн захиргаа” гэснийг “Хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 17 дугаар зүйлийн 17.4.3 дахь заалтын “хяналтын байгууллага болон боомтын аюулгүй байдлыг хангах байгууллагын” гэснийг “хяналтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын” гэж, мөн зүйлийн 17.4.5 дахь заалтын “Боомтын нэгдсэн захиргаанаас” гэснийг “хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэж, мөн зүйлийн 17.5 дахь хэсгийн “Боомтын нэгдсэн захиргаа” гэснийг “хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Боомтын захиргаа нь” гэснийг “Хилийн боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “18.4.7” гэснийг “16.5.14” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Хилийн боомтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.4.4, 17.4.10 дахь заалт, 18 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталсан Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/265 дугаар зүйлийн 265.2, 265.3 дахь хэсэг:

“265.2. Гаалийн байгууллага бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх зааврыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.

265.3. Гаалийн байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.”

2/267¹ дүгээр зүйл:

“267¹ дүгээр зүйл. Гаалийн байгууллагын тогтолцоо



267¹.1.Гаалийн байгууллагын тогтолцоо нь гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооноос бүрдэх бөгөөд гаалийн газар нь алба, салбартай байж болно.

267¹.2.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

267¹.3.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дарга, дэд даргатай байна.

267¹.4.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг, дэд даргыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилно.

267¹.5.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дэргэдээ эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, гаалийн ажилтан бэлтгэх, давтан сургах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага, гаалийн лаборатори, хэвлэх үйлдвэр, мэдээлэл-тооцооллын төв, хөрөнгө оруулалт, хангамж үйлчилгээний газар, эрэлч нохойн албыг байгуулан ажиллуулж болно.

267¹.6.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

267¹.7.Гаалийн газар, хороо болон энэ зүйлийн 267¹.5-д заасан байгууллагын дүрмийг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

267¹.8.Энэ зүйлийн 267¹.5-д заасан эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиар зохицуулна.

267¹.9.Гаалийн байгууллага нь хилийн боомтын хяналтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, ерөнхий зохицуулалтаар хангах тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох харилцааг Хилийн боомтын тухай хуулиар нарийвчлан зохицуулна.”

3/268¹ дүгээр зүйл:



“268¹ дүгээр зүйл.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

268¹.1.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

268¹.1.1.гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

268¹.1.2.гаалийн асуудлаар санал боловсруулж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

268¹.1.3.эрсдэл тооцох системд үндэслэсэн гаалийн хяналтын стратегийг тодорхойлох;

268¹.1.4.гаалийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;

268¹.1.5.гаалийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

268¹.1.6.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон энэ хуульд заасан дүрэм, журам, зааврыг боловсруулах;

268¹.1.7.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх;

268¹.1.8.барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн үндэсний код боловсруулах;

268¹.1.9.бараа мэдүүлэх, гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагыг тогтоох;

268¹.1.10.гаалийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;

268¹.1.11.гаалийн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, гаалийн харилцаанд оролцогчийн мэргэжилтэнг бэлтгэх, сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх;

268¹.1.12.гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;



268¹.1.13.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
268¹.1.14.гаалийн асуудлаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

268¹.1.15. хуульд заасан бусад бүрэн эрх.”

4/269¹ дүгээр зүйл:

“269¹ дүгээр зүйл.Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг

269¹.1.Гаалийн байгууллага дараахь үндсэн үүргийг гүйцэтгэнэ:

269¹.1.1.гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

269¹.1.2.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих;

269¹.1.3.гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих;

269¹.1.4.гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах;

269¹.1.5.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах;

269¹.1.6.гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах;

269¹.1.7.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

269¹.1.8.гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

269¹.1.9.энэ хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах.”



5/270¹ дүгээр зүйл:

“270¹ дүгээр зүйл.Гаалийн байгууллагын эрх

270¹.1.Гаалийн байгууллага дараахь эрх эдэлнэ:

270¹.1.1. энэ хуульд заасны дагуу гаалийн зорилгоор мэдээлэл, бичиг баримт шаардах, шалгах;

270¹.1.2.өөрийн тээврийн болон холбооны хэрэгслийг ашиглах боломжгүй нөхцөл байдлын үед бусдын тээврийн болон холбооны хэрэгсэл ашиглах;

270¹.1.3.гаалийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах;

270¹.1.4.хуульд заасан бусад эрх.”

6/271¹ дүгээр зүйл:

**“271¹ дүгээр зүйл.Гаалийн байгууллагын удирдлагын
бүрэн эрх**

271¹.1.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

271¹.1.1.гаалийн үйл ажиллагааг өдөр тутмын зохион байгуулалтын удирдлагаар хангах;

271¹.1.2.гаалийн хууль тогтоомжоор эрх олгосон бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар батлах;

271¹.1.3.гаалийн бодлого боловсруулахад оролцох, тарифын болон тарифын бус хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

271¹.1.4.гаалийн асуудлаар байгуулах Монгол Улсын олон улсын гэрээний төслийг боловсруулах, Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон тохиолдолд олон улсын гэрээнд гарын үсэг зурах, гэрээгээр Монгол Улсын хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах;

271¹.1.5.гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг гаалийн хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;



271¹.1.6.гаалийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор гаалийн харилцаанд оролцогчидтой хамтран ажиллах;

271¹.1.7.гаалийн асуудлаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан үзэж, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах;

271¹.1.8.гаалийн удирдах төв байгууллагын харьяа болон дэргэдэх байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

271¹.1.9.харьяа гаалийн байгууллагын хариуцах хяналтын нутаг дэвсгэрийг тогтоох, тэдгээрийн эрх хэмжээг тодорхой бараа, тээврийн хэрэгсэл болон гаалийн бүрдүүлэлтийн горимоор хязгаарлах;

271¹.1.10.гаалийн алба хаагчийг томилох, чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох;

271¹.1.11.гаалийн улсын байцаагчийн эрх олгох, эрхийг нь түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах;

271¹.1.12.хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд гаалийн байгууллагын төсөв, хөрөнгийг захиран зарцуулах;

271¹.1.13.гаалийн байгууллагыг гадаад, дотоодод болон шүүх, арбитраж төлөөлөх;

271¹.1.14.гаалийн болон бусад татвар, хураамжийн ногдуулалт, төлөлт, хураалтад хяналт тавих;

271¹.1.15.гадаад худалдааны төлбөр тооцоонд гаалийн зорилгоор хяналт тавих;

271¹.1.16.улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартын дагуу гаалийн удирдах төв байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд гаалийн харилцаанд оролцогчид гаалийн итгэмжлэл олгох;

271¹.1.17.хуульд заасан бусад бүрэн эрх.

271¹.2.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын эзгүйд түүнийг дэд дарга орлоно.”

7/272¹ дүгээр зүйл:

“272¹ дүгээр зүйл.Төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах



272¹.1.Гаалийн байгууллага энэ хуулийн 288, 289 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагатай хамтран ажиллаж болно.

272¹.2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналт хийхээс бусад үүргийг холбогдох хуулийн дагуу төрийн бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно.”

8/281 дүгээр зүйлийн 281.3 дахь хэсэг:

“281.3.Гаалийн улсын байцаагчид цол, түүний нэмэгдэл олгох журмыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

9/293¹ дүгээр зүйл:

**“293¹ дүгээр зүйл.Гаалийн болон бусад татвар
төлөхөөс зайлсхийх**

293¹.1.Гаалийн үнэ, барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, марк, зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлэх, гаалийн бичиг баримтыг солих, засварлах зэрэг аргаар гаалийн болон бусад татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

293¹.2.Энэ зүйлийн 293¹.1-д заасан зөрчлийг болгоомжгүйгээр үйлдсэн бол буруутай этгээдэд Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

293¹.3.Гаалийн болон бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан барааг зориулалтын бусаар захиран зарцуулсан, үрэгдүүлсэн бол улсын хилээр оруулсан өдрийн, хэрэв энэ өдрийг тогтоох боломжгүй бол зөрчил илэрсэн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн хууль тогтоомж, валютын ханш, тарифыг үндэслэн гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлбөл зохих албан татварын дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль ногдуулна.”

10/294¹ дүгээр зүйл:

“294¹ дүгээр зүйл.Татварыг хугацаанд нь төлөхгүй байх

294¹.1.Гаалийн болон бусад татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын үнийн дүнгээс хугацаа хожимдуулсан хоног тутамд

0.3 хувийн хүү ногдуулах бөгөөд энэ заалтын “хүү” гэсэн ойлголт нь Иргэний хуулийн “анз” гэсэн ойлголтод үл хамаарна.”

11/295¹ дүгээр зүйл:

“295¹ дүгээр зүйл.Дансны гүйлгээг хаах, эд хөрөнгийг битүүмжлэх

295¹.1.Гаалийн газар, хорооны даргын шийдвэрээр энэ хуулийн 290.1, 290.2, 291 дүгээр зүйлд заасан барааны үнийг болон 293¹.1, 293¹.2, 294¹.1 дүгээр зүйлд заасан татвар, торгуулийг үл маргах журмаар холбогдох этгээдийн данснаас нь гаргуулан авч, улсын орлого болгох ба боломжгүй бол дансны гүйлгээг нь хаах буюу татвар, төлбөртэй тэнцэх хэмжээний эд хөрөнгийг нь битүүмжилнэ.”

2 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “шаардлагыг тогтоох” гэсний дараа “гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх,” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” гэсний дараа “, Хилийн боомтын тухай хууль” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 265 дугаар зүйлийн 265.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“265.1.Гаалийн байгууллага нь Монгол Улсын гаалийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага мөн.”

4 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/20¹ дүгээр зүйл:

“20¹ дүгээр зүйл.Татварын албаны бэлгэ тэмдэг

20¹.1.Татварын алба нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

2/21¹ дүгээр зүйл:

“21¹ дүгээр зүйл.Татварын албаны дүрэм

21¹.1.Татварын албаны дүрмийг Засгийн газар батална.”

3/22¹ дүгээр зүйл.

“22¹ дүгээр зүйл.Татварын албаны чиг үүрэг

22¹.1.Татварын алба дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22¹.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;

22¹.1.2.татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

22¹.1.3.улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.”

4/23¹ дүгээр зүйл:

“23¹ дүгээр зүйл.Татварын алба, татварын улсын байцаагчийн үйл ажиллагааны зарчим

23¹.1.Татварын алба, татварын улсын байцаагч нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн



эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд захирагдах зарчим баримтална.”

5/24¹ дүгээр зүйл:

“24¹ дугаар зүйл.Татварын алба, татварын улсын байцаагчийн хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах зарчмыг хангах

24¹.1.Татварын алба, татварын улсын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгон ажиллана.

24¹.2.Хувь хүн, хуулийн этгээд, албан тушаалтан нь татварын алба, татварын улсын байцаагчаас хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглох бөгөөд зөрчсөн этгээдийн талаар холбогдох байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

24¹.3.Татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар хууль тогтоомжоор эрх олгосноос бусад этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

24¹.4.Хууль тогтоомжоор эрх олгосноос бусад тохиолдолд аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээхийг хориглоно.

24¹.5.Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан татварын албаны удирдах дээд байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг хуулийн этгээд, хувь хүн дагаж мөрдөнө.”

6/25¹ дүгээр зүйл:

“25¹ дүгээр зүйл.Татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг хангах

25¹.1.Татварын алба, татварын улсын байцаагч энэ хуулийн 14 дүгээр зүйлийг дагаж мөрдөн татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг хангана.”

7/26¹ дүгээр зүйл:

26¹ дүгээр зүйл.Татварын албаны төсөв



26¹.1.Татварын албаны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.”

8/27¹ дүгээр зүйл:

**“27¹ дүгээр зүйл.Татварын албаны удирдлага, түүний
бүрэн эрх**

27¹.1.Татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

27¹.2.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтэс татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, дүүргийн татварын хэлтэс, сумын татварын улсын байцаагч аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн удирдлага доор тус тус ажиллана.

27¹.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, төсөв хөрөнгөөр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

27¹.4.Аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн татварын хэлтсийн даргыг нийслэлийн татварын газрын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

27¹.5.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга болон аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг санхүү, эдийн засаг, бүртгэлийн мэргэжилтэй, татварын албанд гурваас доошгүй жил ажилласан, татварын улсын байцаагчийн эрх бүхий төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.

27¹.6.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан татварын улсын байцаагчийн бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27¹.6.1.үндэсний татварын алба, татварын улсын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтын удирдлага,



төсөв хөрөнгөөр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;

27¹.6.2.энэ хууль болон татварын бусад хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлалыг баталж мөрдүүлэх, зөвлөмж гаргах;

27¹.6.3.татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл хүлээлгэх;

27¹.6.4.татварын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргах;

27¹.6.5.татварын хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, тэдгээрийг татварын албанаас хэрэгжүүлэх арга, хэлбэр, боломжийн талаархи саналаа бэлтгэж Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулах;

27¹.6.6.орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын гэрээний төсөлд санал өгөх;

27¹.6.7.татварын улсын байцаагчийн тогтоосон акт, дүгнэлт, бусад шийдвэрийг хуулийн хүрээнд хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгох;

27¹.6.8.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хянаж баталгаажуулах, эсхүл өөрчлөх, хүчингүй болгох;

27¹.6.9.үндэсний татварын албаны ажилтныг томилох, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, шагнаж урамшуулах;

27¹.6.10.үндэсний татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах.”

9/37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг:

“37.3.Татварын улсын байцаагчид цол олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”



10/71¹ дүгээр зүйл:

**“71¹ дүгээр зүйл.Банк, санхүүгийн болон холбогдох бусад
байгууллагын хүлээх үүрэг**

71¹.1.Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар доор дурдсан байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

71¹.2.Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага:

71¹.2.1.харилцагч татвар төлөгчийн татварын төлбөрийг татварын албанаас нэрлэсэн банкинд 12 цагийн дотор, уг төлбөрийг хүлээн авсан банк нь энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу тухайн өдөрт нь, хэрэв ажлын цаг дууссан бол дараагийн ажлын өдөрт багтаан татварын албаны харилцах дансаар дамжуулан төрийн сангийн дансанд шилжүүлэх;

71¹.2.2.татвар төлөгч нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу банкинд шинээр дан нээсэн, эсхүл хуучин дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийсэн бол харилцагч банк нь энэ тухай мэдээллийг 10 хоногийн дотор татварын албанд өгөх;

71¹.2.3.харилцагчийн өр төлбөрийг дараахь дарааллаар гүйцэтгэх:

71¹.2.3.а.эхний ээлжинд төлүүлэхээр хуульд заасан өр төлбөр;

71¹.2.3.б.дансан дахь мөнгөн хөрөнгөнөөсөө татвар төлөх тухай татвар төлөгчийн хүсэлт, үл маргах журмаар татвар гаргуулах тухай татварын албаны шийдвэрт заасан өр төлбөр;

71¹.2.3.в.банк, санхүүгийн байгууллага, бусад зээлдэгч, нэхэмжлэгчид төлөх өр төлбөр.

71¹.3.Банк нь энэ хуулийн 71¹.2.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол татварын алба гүйцэтгээгүй татварын төлбөрийн дүнгийн 0.3 хувиар тооцон хоног тутам хүү ногдуулна.

71¹.4.Энэ хуулийн 71¹.2.3 дахь заалтад Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй.

71¹.5.Хөрөнгийн бирж:

71¹.5.1.хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн тархалтын тухай мэдээллийг татварын албанд улирал тутам цахим хэлбэрээр гаргаж өгөх.

71¹.6.Цагдаагийн байгууллага:

71¹.6.1.татварын алба, татварын улсын байцаагчаас татвар төлөгчийн байр, агуулахад нэвтрэн орох болон шалгалт, тооллого, үзлэг хийх, хөрөнгө барьцаалах, битүүмжлэх үйл ажиллагааг хуульд заасны дагуу явуулахад хүч хэрэглэх буюу зохион байгуулалттайгаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд шаардлагатай туслалцаа үзүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоо бүрдүүлэх;

71¹.6.2.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон өөрт нь байгаа хувь хүний нууцад үл хамаарах мэдээ, судалгааг татварын албаны хүсэлтээр гаргаж өгөх;

71¹.6.3.татвар төлөхөөс зайлсхийж оргон зайлсан татвар төлөгчийг эрэн сурвалжлах ажилд туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;

71¹.6.4.хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын удирдлага нь татварын албанаас шалгуулахаар шилжүүлсэн татварын хэрэг, зөрчлийг хуульд заасан хугацаанд шалган шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, дүнг татварын албанд бичгээр мэдэгдэх, түүнчлэн өөрийн илрүүлсэн татварын хууль тогтоомжийн зөрчлийн мэдээллийг татварын албанд шилжүүлж өгөх.

71¹.7.Гаалийн байгууллага:

71¹.7.1.татвар төлөгчийн регистрийн дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгуулж, экспорт, импортынх нь үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг татварын албатай тохиролцсон хугацаанд гаргаж өгөх.

71¹.8.Иргэний бүртгэл, мэдээллийн болон гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон өөрт байгаа хувь хүний нууцад үл хамаарах мэдээ, судалгааг татварын албаны хүсэлтээр гаргаж өгнө.



71¹.9.Төрийн захиргааны төв, орон нутгийн бусад байгууллага, тэдгээрийн удирдлага, албан тушаалтан:

71¹.9.1.татварын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

71¹.9.2.татварын орлогоос санхүүжигдэж байгаа төсвийн зарлага, зарцуулалтын үр өгөөжийг салбар, байгууллагынхаа жишээн дээр тулгуурлан тайлбарлан сурталчлах, боломжтой хэлбэрээр тайлагнах;

71¹.9.3.татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангаж, татварын албатай хамтран ажиллах;

71¹.9.4.хяналт шалгалт эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ биелүүлэх явцад татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээлэл олж мэдсэн, илрүүлсэн бол энэ тухай мэдээллийг татварын албанд албан ёсоор өгөх.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйл:

“19 дүгээр зүйл.Татварын албаны бүтэц

19.1.Татварын алба нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ.

19.2.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын төсвийн орлого, хяналт, сургалт, бүртгэл мэдээлэл, хэвлэлийн харьяа нэгжтэй байж болно.

19.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн татварын албаны дэргэд татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Татварын маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд уг зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.”

2/28 дугаар зүйл:

“28 дугаар зүйл.Татварын албаны бүрэн эрх

28.1.Татварын алба дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.татварын хууль тогтоомжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг мөр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

28.1.2.татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх аргачлал, заавар, мэдээллээр татвар төлөгчдийг хангаж, зөвлөлгөө өгч үйлчлэх;

28.1.3.татвар төлөгч хуулийн дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;

28.1.4.татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх;

28.1.5.татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулан мэдээллийн сан бүрдүүлж, татварын хяналт шалгалт, хураалтын үйл ажиллагаанд ашиглах;

28.1.6.анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй татвар төлөгчид хуульд заасны дагуу татвар ногдуулах;

28.1.7.тогтоосон хугацаанд татвар төлөөгүй хуулийн этгээдийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох;

28.1.8.татварын өрийг барагдуулах, татвар хураах үйл ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулах;

28.1.9.илүү төлсөн татварыг дараачийн сар, улирал, жилийн татварт суутган тооцох буюу татвар төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 10 хоногийн дотор буцаан олгох;

28.1.10.татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн, татварын мэдээ, тайлан, татварын хяналт шалгалтад шаардлагатай материалыг хугацаанд нь ирүүлээгүй, түүнчлэн татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй татвар төлөгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;



28.1.11. татварын улсын байцаагч, доод шатны татварын албаны гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх;

28.1.12. татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг хувь хүн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

28.1.13. цахим үйлчилгээ үзүүлэх;

28.1.14. цахим хяналт шалгалт явуулах.”

28.2. Татварын алба нь шүүхэд дараахь асуудлаар нэхэмжлэл гаргана:

28.2.1. татварын хууль тогтоомж удаа дараа ноцтой зөрчсөн татвар төлөгчийн аж ахуйн үйл ажиллагааг уг зөрчлөө арилгах хүртэлх хугацаагаар түр зогсоох;

28.2.2. татвар төлөгч хууль тогтоомжоор хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж олсон орлогыг хураалгах;

28.2.3. татвар төлөгч хууль тогтоомжоор хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг зохих зөвшөөрөлгүй явуулж олсон орлогыг хураалгах;

28.2.4. татвар төлөгчийн хүчин төгөлдөр бус гэрээ хэлцэл, хууль бус үйлдлээр олсон орлогыг хураалгах;

28.2.5. албан үүргээ гүйцэтгэхэд нь татварын улсын байцаагчид саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, амь бие, эрүүл мэндэд нь халдаж хохирол учруулсан;

28.2.6. хууль тогтоомжид заасан бусад асуудлаар.”

3 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 дэх хэсгийн “Гааль, татварын ерөнхий газрын” гэснийг “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг хассугай.



5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 1, 3, 4, 6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж, 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “Гадаадын иргэн, харьяатын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтын “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.12 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1, 28.3, 28.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 29.3, 29.4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1, 30.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2, 36.3 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2, 37.4, 37.6 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3 дахь хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэний” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4, 36.6 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.3, 37.5, 37.8 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Наймдугаар бүлгийн нэр, 40, 41 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3, 41.4 дэх хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “Гадаадын иргэний” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8, 5.10 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж, 6 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “Гадаадын иргэн, харьяатын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.7 дахь хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.11 дэх заалтын “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсгийн “иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний” гэснийг “гадаадын иргэн, харьяатын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Бямбадоржийн Болдбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Цэдэвийн Цолмонг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Найдансүрэнгийн Золжаргалыг өөрийн хүсэлтийг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилох тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Надмидын Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2016 оны
12 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТООЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	1.Тагнуулын ерөнхий газар 2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 3.Үндэсний хөгжлийн газар	1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 5.Онцгой байдлын ерөнхий газар 6.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7.Стандарт, хэмжил зүйн газар	
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		2.Цаг уур, орчны шинжилгээний газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8.Зэвсэгт хүчний жанжин штаб	
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		3.Гаалийн ерөнхий газар 4.Татварын ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	9.Цагдаагийн ерөнхий газар 10.Хил хамгаалах ерөнхий газар	5.Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар 6.Архивын ерөнхий газар 7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 8.Гадаадын иргэн, харьяатын газар



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		9.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 10.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 11.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		12.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13.Биеийн тамир, спортын газар 14.Соёл, урлагийн газар
Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		15.Иргэний нисэхийн ерөнхий газар
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		16.Ашигт малтмал, газрын тосны газар
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		17.Мал эмнэлэг, үржлийн газар
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын Байнгын хороодын даргаар доор дурдсан Улсын Их Хурлын гишүүдийг сонгосугай:

1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Жадамбын Энхбаярыг;

2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Цэдэнгийн Гарамжавыг;

3/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг;

4/Өргөдлийн байнгын хорооны даргаар Даваажанцангийн Сарангэрэлийг;

5/Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Нямаагийн Энхболдыг;

6/Төсвийн байнгын хорооны даргаар Чимэдийн Хүрэлбаатарыг;

7/Хууль зүйн байнгын хорооны даргаар Шатарбалын Раднаасэдийг;

8/Эдийн засгийн байнгын хорооны даргаар Дэндэвийн Тэрбишдагыг.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатарыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Жамбалдоржийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар
хот

Дипломат дээд цол хүртээх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсад орчин үеийн дипломат алба үүсч хөгжсөний 104 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын гадаад харилцааны салбарт идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, хичээл зүтгэлийг нь өндрөөр үнэлж, дараах хүмүүст "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд", "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолыг тус тус хүртээж Алтан, Мөнгөн гэрэгэ энгэрийн тэмдгээр шагнасугай.

“Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд” цолоор

1.Баасанжавын Ганболд Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайд



2.Доржийн Энхбат Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

“Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” цолоор

1.Банзрагчийн Одонжил Монгол Улсын Гадаад хэргийн яамны Бодлого төлөвлөлт, зохицуулалтын газрын зөвлөх

2.Гончигийн Ганболд Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

Монгол Улсын цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Ардын хувьсгалын 85 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд барилдсан Монгол Улсын начин Шүхэртийн Уламбаярт “Улсын харцага”, Монгол Улсын харцага Цэрэндашдоржийн Магалжавд “Улсын заан” цол тус тус нөхөн олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 07 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэдэнжавын Сүхбаатарыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбын Ганхуягийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар
хот

“Сайн оюутан” хөтөлбөр батлах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 4.1.2, 5.1.8, 7, 12, 13 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч оюутны бие даасан байдал, хариуцлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сурах бололцоог нэмэгдүүлэх зорилго бүхий “Сайн оюутан” хөтөлбөрийг 1 дүгээр, “Сайн оюутан хөтөлбөрийн зээлийн журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хүрээнд зээл олгох үйл ажиллагааг Төрийн банктай гэрээ байгуулсны үндсэн дээр эхлүүлж, бусад банктай гэрээг үе шаттайгаар байгуулан ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Болор нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын дотоод үнэт цаас гарган бүрдүүлж санхүүжүүлэх арга хэмжээ авч, 2016 оны төсвийн тодотголын төсөл, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Сангийн сайд Б.Болорт даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

“САЙН ОЮУТАН” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь дээд боловсролын байгууллагад суралцаж байгаа оюутны хариуцлагыг дээшлүүлж, түүний өрсөлдөх чадвар, сурах бололцоог нэмэгдүүлж, оюутны сургалтын төлбөрийн зээлийн нөхцөлийг сайжруулахад оршино.

Хоёр. Сургалтын төлбөрийн зээлийн нөхцөлийг сайжруулах

2.1. Оюутны сургалтын төлбөрийн зээлийн нөхцөлийг дараах байдлаар сайжруулна:

2.1.1. сургалтын төлбөрт зориулан авсан цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдлийг шинэ нөхцөлтэй зээлд шилжүүлэх;

2.1.2. оюутанд сургалтын төлбөрийн богино хугацаатай зээл олгох;

2.1.3. оюутанд сургалтын төлбөрийн урт хугацаатай зээл олгох.

2.2. Энэхүү хөтөлбөрийн 2.1-д заасан зээлийн дахин санхүүжилт, шинэ зээлийн төрөл, тавигдах шаардлага, санхүүжилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах ерөнхий журмыг Засгийн газар батална.

2.3. Оюутны сургалтын төлбөрийн зээл олгох журам тогтооход дараах зарчмыг баримтална:

2.3.1. зээлийн нөхцөлийг оюутны сурлагын дүнтэй уялдуулах;

2.3.2. оюутны сурлагын чанар сайжирснаар илүү сайн нөхцөлтэй зээл авах, сургалтын төлбөрийн асуудлаа оюутан бие даан шийдвэрлэх боломж бүрдүүлэх;

2.3.3. оюутан сургалтын төлбөрийн урт хугацаатай зээлд бие даан хамрагдах боломжийг хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан шийдвэрлэх.

2.4. Оюутны сургалтын төлбөрийн зээлийн нөхцөл боломжийг дэмжих хүрээнд дараах арга хэмжээг авна:



2.4.1. боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн зээлийн талаарх мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулж, хөтөлбөрийн ил тод, нээлттэй байдлыг хангана;

2.4.2. хөтөлбөрийн зээлийн хэрэгжилтийн тайланг улирал тутам гаргаж, олон нийтэд мэдээлнэ;

2.4.3. төгсөгчдийн ажил эрхлэлт, орлогын түвшин, төгссөн мэргэжлээрээ ажиллаж байгаа байдал зэрэг асуудлыг хамарсан судалгаа хийх;

2.4.4. хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, үр дүнг олон нийтэд тайлагнана.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. олон талын оролцоог хангаж, эх үүсвэр болон эрсдэлийг хуваалцах;

3.1.2. оюутан, сургуулийн оролцоо, хариуцлагыг илүү тодорхой болгох;

3.1.3. зээлийг банкаар дамжуулан олгох;

3.1.4. зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэх;

3.1.5. хөтөлбөрийн үр дүнг тогтмол үнэлж, боловсронгуй болгох арга хэмжээг авч байх;

3.2. Хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэхдээ дараах журмыг баримтална:

3.2.1. банктэй гэрээ байгуулсны үндсэн дээр эх үүсвэр олгох;

3.2.2. эх үүсвэрийн эргэн төлөгдөх баталгааг банкнаас гаргах энгийн векселиэр баталгаажуулсан байх;

3.2.3. зээлийн эрэлтэд тулгуурлан банкинд эх үүсвэр олгох.



Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн

4.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуураар дүгнэнэ:

4.1.1. оюутны сурлагын голч дүн ахисан байдал;

4.1.2. төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь;

4.1.3. эцэг эхийн авсан сургалтын төлбөрийн зээлийн хүүгийн дундаж төлбөр;

4.1.4. зээлийн эргэн төлөлтийн хувь, зээлийн чанар.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэхдээ нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, дээд боловсролын салбарын зах зээлийн эрэлт хэрэгцээ, тухайн жилийн элсэгчдийн тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг харгалзана.

4.3. Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрсэн байна:

4.3.1. дээд боловсролын сургалтын чанар сайжирч, төгсөгчдийн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;

4.3.2. оюутан санхүүгийн хувьд бие даан суралцах нөхцөл бүрдэж, хариуцлагаа ухамсарласан, өрсөлдөх чадвартай иргэн болж төлөвшинэ;

4.3.3. оюутны суралцах арга барил, чадвар сайжирсан байна;

4.3.4. төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь нэмэгдсэн байна.

Засгийн газрын 2016 оны 229 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**“САЙН ОЮУТАН” ХӨТӨЛБӨРИЙН ЗЭЭЛИЙН
ЕРӨНХИЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зохих журмын дагуу элсэн, өдрийн ангид суралцаж байгаа Монгол Улсын иргэн (цаашид “оюутан” гэх)-д сургалтын төлбөрийн зээл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.



1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дараах байдлаар ойлгоно:

1.2.1. “оролцогч банк” гэж хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан банкийг;

1.2.2. “оролцогч сургууль” гэж хөтөлбөрт оролцохоор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий дээд боловсролын сургалтын байгууллагыг;

1.2.3. “суралцах хугацаа” гэж Монгол Улсын Дээд боловсролын тухай хуульд заасан бакалаврын дээд боловсрол эзэмших сургалтын үндсэн 4-6 жилийн хугацааг;

1.2.4. “оюутны гэр бүлийн гишүүн” гэдэгт эцэг, эх, эмээ, өвөө, төрсөн ах, эгч, дүү, асран хамгаалагч;

1.2.5. “дахин санхүүжилтийн зээл” гэж оюутны сургалтын төлбөрийн зориулалтаар өмнө нь олгогдсон зээлийн үлдэгдлийг шинэ нөхцөлтэй зээлд шилжүүлэх үйл ажиллагааг;

1.2.6. “богино хугацаатай зээл” гэж тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрт зориулан авсан зээлийг;

1.2.7. “урт хугацаатай зээл” гэж суралцах үндсэн 4-6 жилийн хугацаанд жил бүр сургалтын төлбөрийн зориулалтаар хуримтлуулан авсан зээлийг.

1.3. Хөтөлбөрийн зээлийн гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэг, тэдгээрийн хоорондын санхүүгийн хэлцлийн нөхцөлийг тус тусын гэрээгээр зохицуулна.

Хоёр. Зээл, зээлийн санхүүжилт

2.1. Энэхүү журмын хүрээнд дараах 3 төрлийн зээлийг олгоно:

2.1.1. дахин санхүүжилтийн зээл;

2.1.2. богино хугацаатай зээл;

2.1.3. урт хугацаатай зээл.



2.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын үнэт цаас гаргах замаар бүрдүүлсэн хөрөнгийг оролцогч банкинд хугацаатай мөнгөн хадгаламж, эсхүл зээл хэлбэрээр байршуулж, энэхүү журмын 2.1-д заасан зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

2.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дахин санхүүжилтэд зориулан гаргах үнэт цаас, байршуулах мөнгөн хадгаламж, эсхүл зээл нь дараах нөхцөлтэй байна:

2.3.1. хүү (жилийн): 1 хувь;

2.3.2. дүн: дахин санхүүжилтийн зээлийн дүн;

2.3.3. хугацаа (жил): цалингийн зээл: 1.5 жил хүртэлх;
тэтгэврийн зээл: 1 жил хүртэлх.

2.4. Богино болон урт хугацаатай зээл олгоход зориулан гаргах үнэт цаас, байршуулах мөнгөн хадгаламж, эсхүл зээл нь дараах нөхцөлтэй байна:

2.4.1. зориулалт: сургалтын төлбөрийн зээл олгох;

2.4.2. хүү (жилийн): 1 хувь;

2.4.3. дүн: тухайн санхүүгийн жилийн сургалтын төлбөрийн зээлийн эрэлтээс хамаарна;

2.4.4. хугацаа (жил): богино хугацаатай зээл: 1 жил хүртэлх урт хугацаатай зээл: 10 жил хүртэлх

2.5. Оролцогч банк энэхүү журмын 2.3-т заасан эх үүсвэрийг авч байгаа тохиолдолд санхүүжилт хүссэн албан тоот, дахин санхүүжилтийн зээлийн мэдээ, энэхүү журмын 2.4-т заасан эх үүсвэрийг анх удаа авч байгаа тохиолдолд зөвхөн санхүүжилт хүссэн албан тоот, 2 буюу түүнээс дээш удаа авч байгаа тохиолдолд энэхүү журмын 2.6-д заасан баримт бичгийг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.6. Оролцогч банк нь хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийг 2 буюу түүнээс дээш удаа авч байгаа тохиолдолд дараах баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

2.6.1. санхүүжилт хүссэн албан бичиг;



2.6.2. өмнө авсан эх үүсвэрийг ашигласан тухай тайлан;

2.6.3. эрх бүхий албан тушаалтны баталгаажуулсан зээл олгоход шаардагдах эх үүсвэрийн тооцоо;

2.6.4. Засгийн газраас олгосон мөнгөн хадгаламж, эсхүл зээлийг хугацаандаа төлөхийг баталсан энгийн вексель;

2.6.5. хөтөлбөрт оролцох шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг нотлох бусад баримт бичиг.

2.7. Оролцогч банк нь энэхүү хөтөлбөрт зориулан гаргасан өөрийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасыг худалдаж эх үүсвэрийг бүрдүүлнэ.

2.8. Оролцогч банк боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран дараах үйл ажиллагааг өөрийн зардлаар зохион байгуулна:

2.8.1. хөтөлбөр хэрэгжүүлэх зар сурталчилгаа явуулах;

2.8.2. төгсөгчдийн ажил эрхлэлт, орлогын түвшин, төгссөн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх асуудлыг хамарсан судалгаа хийлгэх;

2.8.3. хөтөлбөрийн нийгэм, эдийн засгийн үр ашиг, зардлын шинжилгээ, дүгнэлт хийлгэх.

2.9. Оролцогч сургууль нь энэхүү хөтөлбөрийн урт хугацаатай зээлээр төлөгдсөн оюутны сургалтын төлбөрийн 2 хувийг оролцогч банкинд байршуулж, оюутны зээлийн үүргийн гүйцэтгэлийн 10 хувийг хариуцна.

2.10. Оролцогч банк болон оролцогч сургууль энэхүү журмын 2.9-т заасан хөрөнгийг хадгалах, эрсдэл үүссэн тохиолдолд уг хөрөнгийг зарцуулах харилцааг зохицуулах гэрээ байгуулна.

Гурав. Дахин санхүүжилтийн зээлийн нөхцөл, шаардлага

3.1. Оюутны сургалтын төлбөр төлөх зориулалтаар банкнаас авсан цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдлийг дахин санхүүжүүлэх арга хэмжээг зөвхөн 1 удаа авна.

3.2. Дахин санхүүжилтийн хүсэлт хүлээн авах хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон нийтэд зарлана.

3.3. Дахин санхүүжилтийн зээлд хамрагдах оюутан энэхүү журмын 4.2-т заасан шаардлагыг хангасан байна.



3.4. Дахин санхүүжилтэд хамрагдах цалин, тэтгэврийн зээлд дараах шаардлагыг тавина:

3.4.1. оюутны сургалтын төлбөрт зориулан авсан зээлийг, олгосон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор сургуульд нь төлсөн байх;

3.4.2. зээлийг банкнаас 2016 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 4 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд авсан байх;

3.5. Энэхүү журмын 3.4-т заасан шаардлагыг хангасан зээлийг үндсэн төлбөрийн үлдэгдэл болон зээлээр төлсөн сургалтын төлбөрийн аль бага дүнгээр нь тооцож дараах нөхцөлтэй зээлд шилжүүлнэ:

3.5.1. зээлийн хүү жилийн 5 хувь байна.

3.5.2. цалин, тэтгэврийн зээлд тавигдаж байсан бусад нөхцөл хэвээр хадгалагдана.

3.6. Дахин санхүүжилтэд хамрагдах хүсэлтэй оюутны гэр бүлийн гишүүн дараах материалыг бүрдүүлэн оролцогч банкинд хандана:

3.6.1. дахин санхүүжилтийн зээлд хамрагдах хүсэлт;

3.6.2. сургалтын төлбөр төлсөн санхүүгийн баримт;

3.6.3. сургалтын төлбөр төлснийг нотлох оролцогч сургуулийн тодорхойлолт болон сургуулийн дансны хуулга;

3.6.4. гэр бүлийн гишүүн мөн болохыг нотлох баримт, эсхүл Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын лавлагаа;

3.6.5. оюутан нь энэхүү журмын 4.2-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бүрдүүлэх.

3.7. Банк дахин санхүүжилтийн зээлийг олгохдоо дараах зарчмыг баримтална:

3.7.1. дахин санхүүжилтийн зээлийн буцаан төлөлтийг гэр бүлийн гишүүн хариуцсан хэвээр байх;

3.7.2. дахин санхүүжилтийн зээлийг “оюутны зээл” ангилалд бүртгэх.

Дөрөв. Богино хугацаатай зээлийн
нөхцөл, шаардлага

4.1. Энэхүү журмын дагуу олгох богино хугацаатай зээл дараах нөхцөлтэй байна:



4.1.1. зээлийн дүн: оролцогч сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон 1 жилийн сургалтын төлбөрийн хэмжээнээс хэтрэхгүй;

4.1.2. зээлийн хүү (жилийн): 5 хувь;

4.1.3. зээлийн хугацаа (сар): 12 сар хүртэлх;

4.1.4. зээлийн эргэн төлөлт: зээлдэгчийн орлогод суурилсан, сар бүр тэнцүү төлбөрийн хуваарьтай;

4.1.5. үйлчилгээний шимтгэл: оролцогч банкны дотоод журамд заасны дагуу.

4.2. “Сайн оюутан” хөтөлбөрийн богино хугацаатай зээлд хамрагдах оюутан дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1. эрх зүйн бүрэн чадамжтай байх;

4.2.2. оролцогч сургуульд зохих журмын дагуу элссэн эрхийн бичигтэй, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Оюутны мэдээллийн сан”-д бүртгэлтэй байх;

4.2.3. шинээр элсэгчдийн хувьд элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь 400 буюу түүнээс дээш, бусад оюутны хувьд сурлагын голч дүн нь 2.5 болон түүнээс дээш байх;

4.2.4. зээлийн үндсэн зээлдэгч нь оюутан, хамтран зээлдэгч нь түүний гэр бүлийн гишүүн байх;

4.2.5. үндсэн болон хамтран зээлдэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

4.2.6. үндсэн болон хамтран зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй байх.

4.3. Оюутан нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн оролцогч банкинд хандана:

4.3.1. зээл хүссэн өргөдөл;

4.3.2. иргэний болон оюутны үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.3.3. сургуулийн сургалтын төлбөрийн нэхэмжлэл (эх хувиар);



4.3.4. гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.3.5. бүрэн дунд боловсролын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.3.6. сургуульд зохих журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.3.7. гэр бүлийн гишүүний орлогын эх үүсвэрийг баталгаажуулсан баримт;

4.3.8. банкнаас шаардсан бусад баримт.

4.4. Оролцогч банк тухайн оюутанд олгосон зээлийг оролцогч сургуульд бүрэн шилжүүлж, зээлээр сургалтын төлбөр төлөгдсөн болохыг оюутанд мэдэгдэнэ.

Тав. Урт хугацаатай зээлийн нөхцөл,
шаардлага

5.1. Энэхүү журмын дагуу олгох урт хугацаатай зээл дараах нөхцөлтэй байна:

5.1.1. зээлийн дүн: оролцогч сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон 1 жилийн сургалтын төлбөрийн хэмжээнээс хэтрэхгүй;

5.1.2. зээлийн хүү жилийн: 5 хувь;

5.1.3. зээлийн хугацаа: сургууль төгссөнөөс хойш 4 жил хүртэлх хугацаанд эргэн төлнө;

5.1.4. зээлийн эргэн төлөлт: оюутны ирээдүйн орлогод суурилсан;

5.1.5. зээлийн хүүгийн төлбөрийг сар бүр, үндсэн төлбөрийг сургууль төгссөнөөс хойш 1 жилийн дараагаас эхлэн 3 жилийн хугацаанд;

5.1.6. үйлчилгээний шимтгэл: оролцогч банкны дотоод журамд заасны дагуу;

5.1.7. зээлийн давтамж: үндсэн 4-6 жилийн суралцах хугацаанд жилд 2 хүртэлх удаа.



5.2. “Сайн оюутан” хөтөлбөрийн урт хугацаатай зээлд хамрагдах оюутан дараах шаардлагыг хангасан байна:

5.2.1. эрх зүйн бүрэн чадамжтай байх;

5.2.2. оролцогч сургуульд зохих журмын дагуу элссэн эрхийн бичигтэй, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Оюутны мэдээллийн сан”-д бүртгэлтэй байх;

5.2.3. шинээр элсэгчдийн хувьд элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 650 буюу түүнээс дээш, бусад оюутны хувьд сурлагын голч дүн нь 3.5 болон түүнээс дээш байх;

5.2.4. энэхүү журмын 2.9-т заасан оролцогч сургуулийн батлан даалттай байх;

5.2.5. гэр бүлийн гишүүн нь батлан даагч байх;

5.2.6. оюутан нь зээлийн хугацаа дуустал холбогдох хууль тогтоомжийн дагуу амь насны даатгалд хамрагдсан байх;

5.2.7. үндсэн болон хамтран зээлдэгч нь банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

5.2.8. үндсэн болон хамтран зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй байх;

5.2.9. оюутан нь хөтөлбөрийн зээлийг бүрэн төлж дуусталх хугацаанд энэхүү журамд зааснаас бусад төрлийн банкны зээл авахгүй байх нөхцөлийг зөвшөөрсөн байх;

5.2.10. банкны зээлийн нэмэлт шалгуурыг хангасан байх.

5.3. Оюутан дараах бичиг баримтыг бүрдүүлэн оролцогч банкинд хандана:

5.3.1. зээл хүссэн өргөдөл;

5.3.2. иргэний болон оюутны үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;



5.3.3. сургуулийн сургалтын төлбөрийн нэхэмжлэл (эх хувиар);

5.3.4. бүрэн дунд боловсролын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

5.3.5. оролцогч сургуульд зохих журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар.

5.4. Оролцогч банк нь олгосон зээлийн 98 хувийг оролцогч сургуулийн дансанд, 2 хувийг энэхүү журмын 2.9-т заасан зориулалтаар тухайн банкин дахь оролцогч сургуулийн дансанд шилжүүлж, энэ тухайгаа оролцогч сургууль болон оюутанд мэдэгдэнэ.

Зургаа. Мэдээлэл, тайлан

6.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зээлийн мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ.

6.2. Оролцогч банк зээлийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкинд хүргүүлнэ.

6.3. Оролцогч банк зээлдэгчийн зээлийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын боловсролын нэгдсэн мэдээллийн сан болон Монголбанкны зээлийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.

6.4. Оролцогч банк зээлийн мэдээг хөтөлбөр эхэлсэн эхний сард 7 хоног тутамд, 2 дахь сараас эхлэн сар бүр боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Оролцогч банкинд олгосон “Сайн оюутан” хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийн зориулалт, эргэн төлөлтөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

7.2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оролцогч банкнаас оюутанд сургалтын зээл олгох үйл



ажиллагаа энэхүү журам, талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавина.

7.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, ашиглалтад хяналт, шалгалт хийнэ.

7.4. Оролцогч банк оюутанд олгосон сургалтын төлбөрийн зээлийн зориулалт, эргэн төлөлтийг хариуцна.

7.5. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5.25

Индекс: 14003